

АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭД СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЛАЛ

1. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар төсөвт байгууллага, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж, дүгнэлт гаргах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тул оролцох хүсэлтэй аудитын хуулийн этгээд материалаа ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү аудитын хуулийн этгээд нь улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нийлсэн **Багц I - 27, Багц II – 28** байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд Төсвийн тухай хуулийн цаглаварт заасан хугацаанд аудитыг хийж гүйцэтгэнэ.
3. Оролцогч аудитын хуулийн этгээд дараах материалыг ирүүлнэ. Үүнд:
 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
 3. ММНБИ-ын тодорхойлолт
 4. Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /Сүүлийн 3 жилээр/
 5. Үндсэн ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар
 6. Үндсэн ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/
 7. Санхүүгийн тайлан /сүүлийн 2 жилээр/
4. Дээрх жагсаалтаас гадна нэмэлт мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 17-ний 17 цагийн хооронд авч болох бөгөөд материалаа дор дурдсан хаягаар 2022 оны 10 дугаар сарын 21-ны 18 цагаас өмнө цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

Цахимаар хүлээн авах хаяг: umnugovi@audit.gov.mn

Холбоо барих утас: 70533552, 88000529

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар